



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/113

Мандалговь

“Гранд холдинг” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажил”-ын багц-1 (Дундговь, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Адаацаг сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Гранд холдинг” ХХК-тай 201,489,390 (хоёр зуун нэгэн сая дөрвөн зуун наян есөн мянга гурван зуун ер) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Стандартын дагуу “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажил”-ын багц-1 (Дундговь, Адаацаг, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гранд холдинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг), Сайхан-Овоо сумын Засаг дарга (Б.Түвшинбаатар), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар) ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060483